

Батлав: ҮТС-ийн захирал, доктор (Ph.D), дэд проф.

Ж.Туяацэцэг



## “Биотехнологи бидний амьдрал – 2023”

### оюутны эрдэм шинжилгээний бага хурлын удирдамж

#### Удиртгал

“Биотехнологи бидний амьдрал – 2023” оюутны эрдэм шинжилгээний хурал нь ШУТИС, ҮТС-ийн Биотехнологи-шим тэжээлийн салбарын оюутан залууст шинжлэх ухаан, технологийн судалгааны ертөнцөд мөрөө гаргах, судалгааны үр дүнг боловсруулах, асуудалд шүүмжлэлтэйгээр хандах, оюун бодлоо задлах, судалгааны илтгэл бэлтгэх, тавих ур чадварыг хөгжүүлэх сайхан боломжийг олгодог. Түүнчлэн багш судлаач нар сургалтын заах арга, оюутны ирээдүйн хөгжлийн талаар шинийг давхар олж хардаг, ҮТС-тай хамтын ажиллагаатай байгууллагууд ЭШ, инновацийн чиглэлээр цаашид хамтран ажиллах боломж, чиглэлийг нээн олдог өөрийн өвөрмөц онцлог төрхтэй эрдэм шинжилгээ, судалгааны хурал юм. Энэхүү оюутны эрдэм шинжилгээний хуралд биологи, био эрүүл мэнд, биотехнологи, экологи-хүрээлэн буй орчин болон биотехнологийн шинжлэх ухааны техник, технологийн онцгой мэдлэгийг оюуны өмчийн эрхээр баталгаажуулах үндэсний инноваци, интерпренёр судалгааны чиглэлээр бакалавр, ахисан түвшний сургалтанд хамрагдаж буй оюутан залууст ЭШ судалгааны ажлын илтгэл тавих боломж нээлтэй болно.

#### Зорилго

Микробиологи, биотехнологи мэргэжлээр суралцаж буй оюутнуудыг судалгаа шинжилгээний ажилд дадлагажуулах, эрдэм шинжилгээний ажил, бүтээлийг нийтэд таниулан дэмжих, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, онол практикийн мэдлэгийн уялдаа холбоог сайжруулах

#### Зохион байгуулагч

ШУТИС нь Монгол улсын инженер, техникийн дээд боловсролын ууган бөгөөд тэргүүлэгч их, дээд сургуулиудын нэг ба шинжлэх ухаан, технологийн бүхий л салбарт дээд боловсролтой мэргэжилтэнг бэлтгэдэг. ШУТИС, ҮТС-ийн Биотехнологи-шим тэжээлийн салбар нь микробиологи, хүнсний биотехнологи зэрэг мэргэжлүүдээр суралцаж буй оюутнуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, судалгаа, шинжилгээний ажилд дадлагажуулах, мэдлэгээр баялаг бүтээх үндэсний инновацийн үйл ажиллагаатай дээд боловсролыг уялдуулахыг эрхэм зорилгоо болгодог.

#### Хурлын бүртгэл, илтгэл шалгаруулалт

Хурлын бүртгэлийн талаар тус салбарын профессор, доктор (Ph.D), дэд профессор С.Дэлгэрмаатай (99753310), дэд профессор, доктор (Ph.D) Х.Мөнхзаяатай (99101340) дугаараар холбоо барих буюу (ШУТИС-н ҮТС-ийн 437 тоот өрөө), хуралд тавих илтгэл болон судалгааны ажлын бүтээлийг [delgermaa\\_s@must.edu.mn](mailto:delgermaa_s@must.edu.mn), [munkhzaya\\_h@must.edu.mn](mailto:munkhzaya_h@must.edu.mn) хаягаар хүлээн авна. Хурлын материалыг хүлээн авах сүүлчийн хугацаа 2023 оны 04-р сарын 10-ны өдрийн үдийн 12 цагаар дуусгавар болно. Ирүүлсэн материалын шалгаруулалтыг хоёр үе шаттай явуулна. Эхний шатанд ирүүлсэн материалаас бакалавр оюутнуудын 7, магистр оюутнуудын 5 бүтээлийг тус бүр мэргэжлийн багш, судлаачид сонгож 2-р үе шатанд оруулна. Хоёрдугаар үе шатанд шалгарсан 12 бүтээлийг хэлэлцүүлж, байр эзлүүлнэ.

**Илтгэлд тавигдах шаардлага:**

- Судалгаа, туршилтын ажлын шинжлэх ухааны үндэслэл, онол, арга зүйг оновчтой гаргасан байна.
- Монгол улсын хүнсний салбарын хөгжлийн асуудлыг хөндсөн, судалгаа туршилтын тодорхой үр дүнд хүрсэн эрдмийн ажлууд байна

**Илтгэл дүгнэх:**

- Илтгэх ур чадвар 10 оноо
- Шинжлэх ухааны үндэслэл, аргазүй 15 оноо
- Шинэлэг санаа, шийдэл 15 оноо
- Практик ач холбогдол 10 оноо

**Илтгэл дүгнэх**

Илтгэлийн дараах байр эзлүүлж шагнаж урамшуулна.

Нэгдүгээр байр	1	Өргөмжлөл, мөнгөн шагнал
Хоёрдугаар байр	1	Өргөмжлөл, мөнгөн шагнал
Гуравдугаар байр	1	Өргөмжлөл, мөнгөн шагнал
Тусгай байр	1	Өргөмжлөл, мөнгөн шагнал

**Илтгэлийн мэдүүлэгээр нэрсийг дараах хүснэгтийн дагуу бөглөж явуулна уу.**

ҮТС-иас 2023 оны 04-р сард зохион байгуулах “Биотехнологи бидний амьдралд-2023” эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлэх илтгэлүүдийн нэрс ..... /тэнхим, сургуулийн нэр/

№	Илтгэлийн нэр	Удирдагчийн овог нэр, эрдмийн зэрэг, цол	Бакалавр оюутны овог нэр	Тайлбар

**Илтгэлээр ирүүлэх өгүүллийн бичиглэлийн шаардлага:**

Өгүүлэл бүрийн өмнө хураангуй бичигдэнэ. Хураангуйг Times New Roman дээр 10 pt үсгийн өндөртэйгээр Italic хэлбэрээр бичнэ. Хураангуй нь 15 мөр, 200 үгэнд багтсан байна. Өгүүлэлийн гарчиг, доторх дэд гарчигууд том үсгээр бичигдэнэ. Үсгийн фонд, хэмжээ "Times New Roman 12", цаасны дээд, доод, баруун талд 2.5 см, зүүн захаас 3 см зайтай бичнэ. Өгүүллийн төгсгөлд ишлэл татсан ном, зохиолын нэрсийг тавих ба өгүүлэлд иш татсан дарааллаар нь дугаарлана. Жагсаалтыг Times New Roman фонд дээр 9 pt үсгийн өндөртэйгээр бичнэ.

Зохиогчийн тухай: Өгүүллийн эцэст тухайн өгүүллийг бичсэн хүн бүрийн товч намтрыг 8 мөр, 80 үгэнд багтааж Times New Roman фонд дээр 9 pt үсгийн өндөртэйгээр бичнэ. Энд зохиогчийн овог нэр, төгссөн болон эрдмийн зэрэг, цол хамгаалсан сургууль, удирдагч, судалгааны ажлын чиглэл, судалгааны лабораторийн тухай бичнэ.